


**БАТЛАВ.
УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН**



Г.ТЭМҮҮЛЭН

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хууль, тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7 дахь хэсэгт "...Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна, Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно" гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв, санхүү, улсын эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой дараах зорилт, арга хэмжээг тодорхойлсон. Үүнд: Үзэл баримтлалын 3.2.3.Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 3.2.3.2.Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна. Мөн 3.2.2.Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогыг хангах зорилтын хүрээнд 3.2.2.1.Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ. 3.2.2.2.Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална. гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны "Зорилт 4.1.2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна", "Зорилт 5.2.4.Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хамтын ажиллагаа бэхжих нөхцөл бүрдэнэ." гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд Төсвийн хуулийн шинэчлэл хийгдэж, төсвийг харилцаанд баримтлах зарчмыг хуульчилсан байна. Үүнд:

- төсвийн тогтвортой байдлыг хангасан байх;
- төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;
- санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;
- ил тод байдлыг хангасан байх;
- хариуцлагатай байх зарчмууд болно.

Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэхэд дээрх зарчмын хэрэгжилт бүрэн дүүрэн хэрэгжиж чадахгүй байна. Тухайлбал, төсвийг боловсруулах батлах үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог хангах ажиллагааг Хууль тогтоомжийн хуулиар хязгаарласан нь төсөв ил тод байх зарчим алдагдаж байна. Ил тод бус төсвийн хуулийн хэрэгжилтээс бид хариуцлага тооцох нөхцөл бүрдэхгүй байна.

Төсвийг боловсруулах, батлуулах үйл явц өөрөө үндэслэл тооцоотой байж, Үндсэн хуульд заагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх нөхцөл бүрдэхээр байна. Гэвч, Төсвийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилсэн хугацаанаас хойш буюу 2012 оны төсвөөс хойших 10 жилийн хугацаанд нийт төсвийн хууль 10 удаа батлагдах ёстойгоос дотогод хийж, нэмэлт, өөрчлөлт оруулснаар 23 удаа төсвийн хуулийг баталжээ.

Монгол Улс 2012 оноос хойш 2012, 2018, 2019 оныг эс тооцвол бүх онуудад 1-2 удаа төсвөө тодотгож ирсэн нь төсвийн бодлого тогтворгүй, төсвийн тооцоолол бодитой бус байсныг илтгэж байна. Тодруулбал, төсвийн тодотголын батлагдсан он цагийг харуулбал:

- 2012 оны төсөв
- 2013 оны төсөв , 2013.10.25-нд тодотгол 1 удаа
- 2014 онд 2014.05.23, 2014.12.18-нд 2 удаа
- 2015 оны төсөв 2015.01.23, 2015.10.30-нд 2 удаа
- 2016 оны төсөв 2016.09.09-нд 1 удаа
- 2017 оны төсөв 2017.04.14, 2017.10.26-нд 2 удаа
- 2018 онд тодотгоогүй
- 2019 онд тодотгоогүй
- 2020 онд 2020.08.28 1 удаа
- 2021 онд 2021.07.07 1 удаа
- 2022 онд 2022.01.31, 2022.04.29-нд 2 удаа

Төсвийн хуулийн үндэслэл болох дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулсан талаарх байдлыг харуулбал:

- 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2011.11.30
- 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2012.10.25
- 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2013.11.14, 2014.05.23
- 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2015.01.23, 2015.10.30
- 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2016.09.09, 2015.11.13
- 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2017.10.26, 2017.04.14
- 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2017.11.14
- 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2018.11.02
- 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2019.11.13, 2020.08.28
- 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2020.11.13, 2021.07.07
- 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2021.11.12, 2022.01.31, 2022.04.29

Монгол Улс 2012-2022 оны хооронд 10 удаа батлах ёстой дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл 30 удаа Улсын их хурлаар хэлэлцэгдэн батлагджээ. Үүнээс үзвэл төсөв тогтвортой, хариуцлагатай, ил тод байх нөхцөл хангалтгүй байна.

Түүнчлэн төсвийг боловсруулах, түүний үндэслэл болох дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх гол үндэслэл болох Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ч өөрчлөх нөхцөлийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хийж иржээ. Тодруулбал,

Төсвийн хуультай хамт хэрэгжиж эхэлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийт 13 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Уг өөрчлөлтүүдийг хийсэн огноог харуулбал:

- 2021.07.07
- 2017.04.14
- 2017.04.14
- 2016.09.09
- 2016.02.05
- 2015.11.10
- 2015.05.21
- 2015.04.09
- 2015.02.18
- 2015.01.20
- 2012.08.17
- 2011.12.23
- 2011.02.10

Дээрх нөхцөл байдлаас харвал, төсвийн тусгай нөхцөл шаардлагыг төсөв батлах болон тодорхой арга хэмжээний шийдвэр гаргах зорилгоор түр түдгэлзүүлэх зэргээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилгыг алдагдуулсан байх эрсдэлтэй гэж сэрдэх үндэслэл бүрдэж байна. Ингэснээр төсвийн тогтвортой байдлыг хангасан байх; төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмууд алдагдах нөхцөл болж байна.

Нөгөө талаас Монгол Улсын жил жилийн төсвийн хууль тогтоомжийг батлуулах явцад үүсдэг хүндрэл нь өрийн тааз, өрийн хэмжээний талаар ихээхэн асуудал яригддаг ч Өрийн удирдлагын хууль тогтоомж болон төсвийн хууль тогтоомжид өрийг хэрхэн үүсгэх бодлогыг яг бодитой тодорхойлоогүй байна. Хүчин төгөлдөр хууль тогтоомжийн зохицуулалт нь авсан зээл, тусламжийг хэрхэн үр дүнтэй зарцуулах асуудал ярьдаг ч анх авахдаа ямар зорилгоор өр үүсгэх ёстой талаарх бодлогыг хуульд тодорхой тусгаагүй нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг зөрчих нөхцөл болж байна.

Төсвийг төлөвлөх батлуулах асуудал нь Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан эрх зүйт төрийн тулгуур зарчим ёсоор гүйцэтгэх засаглалын бүрэн эрх хэмжээний асуудал юм. Засаглалын онолын дагуу Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, түүнээс хариуцлага тооцох эрх бүхий этгээд нь хууль тогтоох эрх хэмжээ бүхий Улсын Их Хурал бөгөөд энэхүү эрх хэмжээний хүрээнд Засгийн газрын боловсруулсан төсөв, гүйцэтгэл зөрүүтэй үед хэрхэн хариуцлага тооцох талаарх хариуцлагатай байх зарчим хуульд тодорхойлогдоогүй байна.

Иймээс ч төсвийг хариуцлагатай байх, бодитой төлөвлөдөг байх, төсвийн төлөвлөлтийг ил тод болгох улмаар төсвийг төлөвлөхөд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг арилгах арга хэмжээг авах нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан суурь зарчмууд хангагдана гэж харж байна.

Дээрх үндэслэл шаардлагын хүрээнд Төсвийн тухай хууль болон болон дагалдах бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар төсвийн ил тод байдлыг хангагдаж, төсвийг хариуцлагатайгаар төлөвлөдөг, батлагдах, захиран зарцуулдаг байх эрх зүйн орчин бүрдэх, улмаар, төсвийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдэх юм.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх; санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, Засгийн газрын боловсруулсан төсвийн төсөлд олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт, төрийн аудитын ажиллах механизмыг тодорхой болгоно. Мөн Засгийн газрын шинэчилсэн бүтцийн хүрээнд эдийн засгийн, хөгжлийн сайдын эрхлэх асуудал нэмэгдсэнтэй холбоотой төсвийн төлөвлөлтөд голлох нөлөөлөх макро эдийн засгийн суурь үзүүлэлтийг тодорхойлох дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах чиг үүргийн харьяаллыг хуульд тодорхой болгоно. Түүнчлэн, төсвийг тодотгох асуудалд илүү үндэслэл тооцоотой хариуцлага байх нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтын дагуу өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүд батлагдсанаар төсвийн ил тод байх, хариуцлагатай байх, төсөв тогтвортой байх зарчмууд хангагдаж, Монгол Улсын төсвийн бодлого, төлөвлөлт тогтвортой, хариуцлагатай байх нөхцөл бүрдэнэ.

Тодруулбал, төсвийн бодлого, төлөвлөлтийг иргэд, олон нийтийн хяналт болон төсвийн тогтвортой байдлын зөвлөл, төрийн аудитын байгууллагын хамтын оролцоо, хяналтаар дүгнэх боломжтой болно. Түүнчлэн Монгол Улсын өрийн удирдлагад баримтлах бодлогыг тодорхой болгож, цаашид зээлийг эдийн засгийн бодит үр ашигтай төслүүдэд зориулж авдаг байх Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал биелэлээ олно.

Эцэст нь төсвийг тодотгох болон төсвийн хүрээний мэдэгдлийг хялбар өөрчилдөг төсвийн тогтворгүй механизмыг халж, хариуцлагатай байх хуулийн орчин бүрдэнэ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн. Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуудийн төсөл болон “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл зэрэг байна.

----oOo----